

Орон нутгийн иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалах талаарх Япон улсын туршлагаас судалсан нь

Шимизү Нацүки 

Бие даасан судлаач, Нара, Япон улс
✉ s.natsuki0213@outlook.jp

Сугарын Энхмэнд 

Хархорум музей, Хархорин, Өвөрхангай, Монгол Улс

Хураангуй: Энэхүү өгүүлэлд зохиогчид Япон улсын Шираока, Минами-Альпс, Хида, Ичинохэ хотуудад иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалах талаар хийж гүйцэтгэсэн туршлага судалгааны ажлын тухай танилцуулах болно. Тус судалгааны үр дүнд үндэслэн иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалахад шаардлагатай гурван хүчин зүйлийг онцлон тэмдэглэж байна. Үүнд:

1. Оролцогчдод тохирсон систем, арга зүй, хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх
2. Төрөөс орон нутагт санхүүгийн дэмжлэг үзүүлэх
3. Оролцогчдоос төрийн бус байгууллага байгуулах

Түүнчлэн, Монгол Улсад дээрх хүчин зүйлсийг хангаж ажиллахад судалгаа шинжилгээ, орон нутгийн засаг захиргаа, төр засгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг тус тус авч үзсэн юм. Үүнд:

- Судалгаа шинжилгээний хувьд иргэдийн оролцоотой соёлын өвийг хадгалж хамгаалах ажлын үр дүн, ач холбогдлыг олон нийтэд сурталчлан таниулж тэдний мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, олон улсын туршлагаас судлан мэдээлэл цуглуулж Монгол Улсад нутагшуулах зорилгоор онол ба практикийн судалгаа явуулах;
- Орон нутгийн засаг захиргааны хувьд орон нутгийн түүх, соёл, амьдралын хэв маяг зэрэг өргөн цар хүрээнд мэдлэгтэй, засаг захиргаа болон иргэдийг хооронд нь холбож хамтын үйл ажиллагааг жигдрүүлэн ажиллах чадвартай соёлын өвийн мэргэжилтэн сургаж бэлтгэх;
- Төр засгийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх болон мэдээлэл хуваалцах нөхцөл боломжоор ханган ажиллах зэрэг арга хэмжээг онцлон тэмдэглэлээ.

Түрхүүр үгс: *эко музей, орон нутгийн өв соёл, хамааралтай хүн ам*

A study of Japan's experience in cultural heritage protection with local community participation

Shimizu Natsuki ✉ 

Independent researcher, Nara, Japan
✉ s.natsuki0213@outlook.jp

Enkhmend Sugar 

Kharkhorum Museum, Kharkhorin, Uvurkhangai, Mongolia

Abstract: In this paper, we first report the results of case study of participatory cultural heritage conservation in Shiraoka City, Minami-Alps City, Hida City and Ichinohe Town in Japan. Secondly, based on the results of the case studies, we pointed out three important points for sustainable participatory cultural heritage protection. 1. Developing and implementing programs, methods, and systems suitable for participants, 2. Providing financial support to local governments from the national government, 3. Organizing participants.

Additionally, we considered the roles that academia, local governments, and the national governments should play in ensuring the above conditions in Mongolia. From an academic perspective, it is necessary to raise public awareness of the importance of community participation in the protection of cultural heritage. Furthermore, it is also important to collect international experience of participatory cultural heritage protection and conduct theoretical and practical studies to find an approach suitable for Mongolia. Local administration should train cultural heritage officers who have extensive knowledge about local history, culture, and lifestyle, and who can connect residents and the government to promote smooth cooperation. The national government should provide financial support to local areas and opportunities for sharing information on participatory protection of cultural heritage.

Keywords: *eco museum, local cultural heritage, related population*

Оршил

Энэхүү өгүүлэлд зохиогчид Япон улсад явуулсан иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалах талаарх туршлагын судалгаанд үндэслэн, Монгол Улсад иргэдийн идэвхтэй оролцоо, тогтвортойгоор соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг нэвтрүүлэхэд шаардагдах тогтолцоо, систем, арга зүйн талаар авч үзэх болно. Түүнчлэн, судалгаа шинжилгээ, орон нутгийн засаг захиргаа, төр засгийн зүгээс анхааралдаа авч ажиллах хэрэгтэй асуудлуудыг онцлон тэмдэглэх зорилготой юм.

Зохиогчид 2015-2016 онд Хархорин сумд “Соёлын өвийг хамгаалах, ашиглахад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж орон нутгийг хөгжүүлэх системийн судалгаа”-ны төслийг хэрэгжүүлсэн. Энэхүү төсөл нь Япон улсын иргэдийн оролцоотой соёлын өвийн хамгаалалтын арга зүй ба шилдэг туршлагаас санаа авч хэрэгжүүлсэн практик судалгаа бөгөөд төслийн дэлгэрэнгүй мэдээллийг тусгайлан өгүүллээс үзэж болно (Shimizu 2016). Энэхүү төслийн үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн иргэдийн соёлын өвийн талаарх сонирхол болон мэдлэгийг

өргөжүүлэн тэлж, соёлын өвийг хамгаалахад иргэдийн оролцоог идэвхжүүлэх зорилгоор доорх үйл ажиллагааг явуулсан.

- 1) Хархорины иргэд орон нутагтаа байгаа ямар соёлын өвийг хэрхэн ойлгож, үнэлж байгааг тодруулж, түүний үндсэн дээр тухайн соёлын өвийн талаар иргэд өөрсдөө бие даан судалгаа хийсэн.
- 2) Орон нутгийн иргэд өөрсдийн судалгааны үр дүнд тулгуурлан үзэсгэлэн зохион байгуулж, үзэгчдэд тайлбарлан таниулж сурталчилсан.

Энэхүү төслөөс дорвитой үр дүн гарсан учраас 2017 оноос хойш тус үйл ажиллагааг Хархорум музейн санхүүжилтээр үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Харин одоогийн байдлаар дээр нэгдүгээрт дурдсан үйл хэрэг орхигдож, хоёрдугаар үйл хэргийн хүрээнд зөвхөн үзэсгэлэн зохион байгуулж байгаа нь анхны зорилго хазайсан хэмээн дүгнэж болно.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан орон нутгийн иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааны явцыг тогтвортой болгоход шаардагдах тогтолцоо, систем, арга зүйг тодруулан гаргаж ирэхийн тулд Япон улсын туршлагаас судлахыг зорьсон юм.

Японы соёлын өвийн хамгаалалтын арга зүйд тулгуурласан практик судалгааг явуулж, түүнээс гарсан ололт амжилтыг дахин Японы соёлын өвийн хамгаалалтын арга зүйн үүднээс тайлбарлах зорилготой энэхүү судалгаа нь онол ба практик хослуулснаар илүү үр өгөөжтэй өвөрмөц судалгаа болно.

Японы соёлын өвийн судалгааны хувьд “Соёлын дурсгал” болон “Соёлын өв” гэсэн хоёр нэр томъёог ялгаж хэрэглэдэг. Энэхүү өгүүлэлд монголчуудын соёлын өвийн тухай хууль эрх зүйн заасан нэр томъёог харгалзан үзэж “Соёлын өв” хэмээх нэр томъёог ашиглах болно. Мөн Япон улсын “Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль (цаашид СДЗХтХ гэх)”-д соёлын дурсгалыг “хамгаалах” гэдгийг “хадгалах” ба “ашиглах” хэмээн заасан байдаг. Тиймээс энэхүү өгүүлэлд “хамгаалах” гэсэн нэр томъёог хадгалах ба ашиглах хэмээн ойлгоно.

Судалгааны арга зүй

Энд зохиогчид баримт бичгийн шинжилгээ, ярилцлагын судалгаа (хагас стандартчилагдсан ярилцлага), хайгуул судалгаа (ажиглалт, ярилцлага)-ны аргуудыг ашигласан болно. Хайгуул судалгааны мэдээлэл 1-р хүснэгтэд харуулсан байна.

Хайгуул судалгааны объектыг сонгохдоо баримт бичгийн шинжилгээний үр дүнгээс бусад тохиолдолд Япон улсын Нарагийн соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэнгийн мэргэжилтнүүдийн зөвлөсний дагуу сонгон шийдвэрлэсэн юм.

Хүснэгт 1. Хайгуул судалгааны ерөнхий мэдээлэл

өдөр	Аймаг, хот	Газар нутаг	Хүн ам	Судалгаанд хамрагдагч
24/10/29	Иватэ аймгийн Ичинохэ хот	300.03км ²	10,460	Иватэ аймгийн Гошоно Жомон археологийн парк ба музей Гошоно Жомон музейн захирал (Археологич мэргэжилтэй)

24/10/30	Сайтама аймгийн Шираока хот	24.88км ²	52,353	Сайтама аймгийн Шираока хотын захиргааны Боловсролын зөвлөлийн насан туршийн боловсролын хэлтэс Ахлах мэргэжилтэн Эрдэм шинжилгээний ажилтан (Хоёулаа археологич мэргэжилтэй)
24/10/31	Яманаши аймгийн Минами-Альпс хот	264.14км ²	71,694	Яманаши аймгийн Минами-Альпс хотын Боловсролын зөвлөлийн Соёлын дурсгалын хэлтэс Мэргэжилтэн (Археологич мэргэжилтэй)
24/11/1	Гихү аймгийн Хида хот	792.5км ²	21,423	Гихү аймгийн Хида хотын Боловсролын зөвлөлийн Соёлын дурсгалын хэлтэс Туслах менежер (Археологич мэргэжилтэй)

Судалгааны үр дүн


1. Япон улсын соёлын өвийн хадгалалт хамгаалалтын тойм

Гол сэдэвтээ орохын өмнө Япон улсад соёлын өвийн хамгаалалтын үндэс болсон СДЗХтХ (1950 онд батлагдсан)-ийн дагуу японы соёлын өвийг хамгаалах тогтолцоог товч танилцуулъя.

1.1 Соёлын өвийн хамгаалалтын цар хүрээний тэлэлт, шинэчлэл

1950 онд СДЗХтХ анх батлагдахад соёлын биет өв, соёлын биет бус өв, дурсгалын цогцолбор хэмээн гурван ангилалтай байсан. 1975 оны хуульд нэмэлт өөрчлөлт оруулж “Угсаатны соёлын дурсгал”, “Уламжлалт уран барилгын цогцолбор” гэсэн хоёр ангилал шинээр нэмсэн байдаг. “Уламжлалт уран барилгын цогцолбор” гэдэг ойлголт бол өнөөг хүртэл ашиглагдаж байгаа уламжлалт барилгуудын хотхоныг хүрээлэн буй орчинтой нь хамт хамгаалалтын бүс тогтоон хамгаалах үйл ажиллагаа юм. Мөн 2004 онд “Соёлын ландшафт” хэмээх ангилал нэмэгдсэн. “Соёлын ландшафт” нь хөдөө аж ахуй, загасны аж ахуй зэрэг хөдөлмөрийн үйл ажиллагаатай холбоотой бий болсон ландшафтыг хэлнэ. Ийнхүү өнөөгийн зургаан ангилал бий болсон байна. Мөн газрын хэвлийн соёлын дурсгал, соёлын дурсгалыг хадгалах арга техникүүд гэсэн тусгай ангилал бас хуулиар зохицуулж өгсөн байдаг (Зураг 1).

Сүүлийн жилүүдэд орон нутагт буй соёлын өвийг улсын хамгаалалтад авсан эсэхээс үл хамааран, олон төрлийн соёлын биет болон биет бус өвийг цогцоор нь харж, түүний түүх, соёлын хамаарал бүхий тодорхой ай саваар нь бүлэглэн авч үздэг “Хамааралтай соёлын дурсгалуудын цогцолбор” хэмээн шинэ үзэл баримтлал бий болсон байна (Agency for Cultural Affairs 2021). Тухайлбал, дангаараа өндөр ач холбогдолгүй, хуулиар хамгаалалтад аваагүй соёлын өвүүдийг байгаль, хүрээлэн буй орчинтойгоо, бусад соёлын өвүүдтэй хэрхэн харилцан хамааралтай байгааг тогтоож, цогц нь харахад орон нутгийн түүх, соёлын өвөрмөц шинж чанарыг илтгэн харуулах соёлын өв гэдэг шинэ үнэ цэнийг бий болгох боломж бүхий үзэл баримтлал юм.



Зураг 1. Япон улсын түүх, соёлын дурсгалт зүйлийн ангилал, ялгаа

Ийнхүү Япон улсад соёлын өвийг хамгаалах тогтолцоог анх бүрдүүлэхдээ соёлын өвийг дангаар нь хамгаалдаг байсан бол дараа нь түүнийг хүрээлэн буй орчны хамт цогцоор нь хамгаалах болсон. Түүнчлэн сүүлийн үед орон нутагт буй олон төрлийн соёлын биет болон биет бус өвүүдийн хоорондын харилцан хамаарал, тухайн соёлын өвийн оршин байх орон зайтай хамтад нь хамгаалах чиг хандлага ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл, Япон улсад соёлын өвийн хадгалалт хамгаалалтын хамрах цар хүрээг өргөжүүлэн тэлэх чиг хандлагатай болсон хэмээн дүгнэж болно.

1.2. Соёлын өвийн төрөлжүүлсэн хамгаалалтын арга

Япон улсад соёлын шилдэг дурсгалууддаа голлон анхаарах зарчмаар соёлын өвийг тогтоож хамгаалдаг юм. Үүнийг “Нэрлэх тогтолцоо” гэдэг бөгөөд 50 жилээс дээш насжилттай соёлын өвийг л хамруулдаг байсан. Гэвч хуулийн зохицуулалтгүй шинэ үеийн соёлын өвүүд нь устаж үгүй болох аюулд өртөх нөхцөл байдал үүссэн. Энэхүү асуудлыг шийдвэрлэхээр 1996 онд шинээр “Бүртгэх тогтолцоо”-г гарган ирж хуулиар зохицуулсан. Бүртгэх тогтолцоо нь нэрлэх тогтолцооноос харьцангуй зөөлрүүлсэн зохицуулалттай бөгөөд харин төр засгаас авах санхүүгийн дэмжлэг нь бага байдаг. Харин “Уламжлалт уран барилгын цогцолбор” ба “Соёлын ландшафт” нь өнөөгийн оршин суугчдын ахуй амьдралтай гүн гүнзгий холбоотой байдаг соёлын өв учраас орон нутгийн засаг захиргааны нэр дэвшүүлснийг харгалзан үзээд, түүнээс сонгож хамгаалалтад авдаг зарчимтай.

2018 онд Японы засгийн газар СДЗХтХ-д нэмэлт өөрчлөлт оруулснаар аймгийн захиргаанаас гаргасан “Соёлын өвийг хамгаалах үндэсний төлөвлөгөө”-ний дэд төлөвлөгөө болох “Соёлын өвийг хамгаалах орон нутгийн ерөнхий төлөвлөгөө (цаашид “орон нутгийн төлөвлөгөө” гэх)”-г тухайн орон нутаг нь боловсруулан Соёлын хэрэгжилтийн агентлаг (цаашид СХА гэх)-г өргөдөл гаргаж, түүнээс батлагдвал улсаас санхүүжилт авах давуу эрхтэй болсон. Энэхүү төлөвлөгөөнд дээр дурдсан “Хамааралтай соёлын дурсгалуудын цогцолбор” гэх мэт өнөөгийн мөрдөгдөж буй хуулиар хамгаалалтад авах боломжгүй соёлын өвүүдийг ч мөн хамруулж болно.

Япон улсад соёлын өвийн хадгалалт хамгаалалтын цар хүрээг өргөжүүлэн тэлсний зэрэгцээ хамгаалалтын аргыг ч мөн төрөлжүүлсэн гэж болно. Харин хүн амын тооны бууралт ба хөгшрөлтийн асуудал тулгарч байгаа Япон улсад соёлын өвийг хамгаалах хүний нөөц дутагдалтай болсон учраас соёлын өвийг хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоо маш чухал хэмээн үздэг. Соёлын өвийг хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог чухалчлан авч үзэх болсон Япон улсад орон нутгийн засаг захиргаа болон соёлын өвийн мэргэжилтнүүдийн гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэх болсон.

2. Хайгуул судалгааны үр дүн

Энд Япон улсад явуулсан хайгуул судалгааны үр дүнд илэрсэн орон нутгийн иргэдийн идэвхтэй оролцоотойгоор соёлын өвийг хамгаалдаг дөрвөн хотын шилдэг туршлагын тухай дурдах болно.

2.1. Сайтама аймгийн Шираока хот

Шираока хот нь Сайтама аймгийн¹ зүүн хэсэгт орших бөгөөд Токиогоос 52 км орчим зайтай. Шираока хотод “Орон нутгийн өв соёлын систем” хэмээх соёлын өвийг хамгаалах арга зүйг боловсруулан гаргаж орон нутгийн засаг захиргаа болон иргэдтэй хамтарч соёлын өвөө хамгаалдаг.

“Орон нутгийн өв соёл” нь СДЗХтХ-ийн үнэлгээнээс үл хамааран, тухайн орон нутгийн иргэд өөрсдийн үзэл бодол, үнэлэмжээр хамгаалвал зохистой гэж шийдвэрлэсэн соёлын болон байгалийн, биет ба биет бус өвийг хамааруулан авч

¹ Энэхүү өгүүлэлд Япон улсын засаг захиргааны хамгийн том үндсэн нэгж болох “кэн”-г “аймаг” гэх.

үздэг ойлголт юм. Мөн “Орон нутгийн өв соёл”-ыг хайгуул судалгаа явуулж, сурвалжлан олж тогтоон, хамгаалахыг “орон нутгийн өв соёлын систем” гэж нэрлэдэг. Энэхүү системийг орон нутгийн иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалахаар Япон улсын зарим нэг орон нутгийн захиргаа нь хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шираока хотод иргэдээс авсан саналд үндэслэн шийдвэрлэсэн зургаан бүлэг сэдвийн дагуу орон нутгийн өвөрмөц шинж чанарыг илтгэн харуулж чадах “Хамааралтай соёлын дурсгалуудын цогцолбор”-ыг тогтоосон юм. Түүнчлэн энэхүү “Хамааралтай соёлын дурсгалуудын цогцолбор”-ын бүрэлдэхүүнд багтах соёлын өвийг (хууль журмаар хамгаалалтад авсан эсэхийг үл хамаарах) “Шираока өв соёл” гэж нэрлэсэн байна.

Цаашид Шираока хот нь иргэдийн санаачилгаар “Шираока өв соёл”-ыг нэмж баяжуулах зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд “Шираока өв соёлын систем”-ийн төлөвлөгөөг боловсруулан дээр дурдсанчлан “Орон нутгийн төлөвлөгөө”-нд тусгуулж чадсан бөгөөд СХА-аас тус төлөвлөгөөг нь 2021 онд баталсан байна. “Шираока өв соёлын систем”-ийг хууль ёсны дагуу “орон нутгийн төлөвлөгөө”-нд оруулах арга замаар шийдвэрлэж, өнөөг хүртэл хууль журмаар хамгаалах боломжгүй байсан орон нутгийн соёлын өвүүдийг тогтвортой хамгаалах нөхцөлийг бүрэн бүрдүүлж чаджээ.

Шираока өв соёлын систем нь иргэдийн нэр дэвшүүлсэн соёлын өвийг “Шираока өв соёлыг хадгалж, ашиглах иргэдийн төлөөлөгчдийн хурал”-д хэлэлцүүлэн батлуулдаг юм. Нэр дэвшүүлэхэд тухайн соёлын өвийн мэдээллийн сантай хамт хамгаалалтын төлөвлөгөөг гаргах шаардлагатай байдаг. Өөрөөр хэлбэл, иргэдийн санал хүсэлтэд үндэслэн, түүнийгээ иргэд өөрсдөө баталгаажуулж, хамгаалалтыг нь хариуцан ажиллах системтэй гэж хэлж болно. Орон нутгийн засаг захиргааны соёлын өвийн ажилтнууд нь энэхүү системийн бүх шатны ажилд оролцон иргэдтэй идэвхтэй хамтран ажилладаг.

2.2. Яманаши аймгийн Минами-Альпс хот

Минами-Альпс хот нь Токио хотоос баруун тийш 200 гаруй км зайд оршино. 2003 онд зургаан хот тосгоныг нэгтгэн шинээр зохион байгуулалт хийсэн хот билээ. Шинээр хот байгуулагдах үед иргэд төдийгүй орон нутгийн захиргааны албан хаагчид ч гэсэн орон нутгийн соёлын өвд анхаарал хандуулдаггүй байсан. Харин тус хотын захиргааны Соёлын дурсгалын хэлтсийн мэргэжилтэн нь иргэдэд соёлын өвийн үнэ цэн, ач холбогдлыг ойлгуулахын төлөө хүчин чармайлт гаргаж ажилласны үр дүнд иргэдийн соёлын өвийн талаарх ойлголт мэдлэг тэлж, 2009 онд иргэдийн хүсэлтээр Орон нутгийн уламжлалын музей ашиглалтад орсон түүхтэй.

Минами-Альпс хотын иргэдийн оролцоотой хамгийн онцгой үйл ажиллагааны нэг бол “Орон нутгийн мару мару музей”² хөтөлбөр юм. Энэ нь байшин барилга бүхий бодит музей биш. Харин тус хотын бүх талбайг музей хэмээн харж, орон

² Энд “мару мару” гэдэг үгийг хоёр утгаар хэрэглэж байгаа. Нэг нь аливаа үг оруулсан ч болох “чөлөө” гэдэг утгатай. Нөгөө утга нь иж бүрэн гэсэн утгатай. Хоёулаа орон нутагт байгаа аливаа нэгэн зүйлс музейн үзмэр ч болох боломжтой гэдэг утгыг илэрхийлсэн юм.

нутагтаа байгаа түүх, соёлын дурсгалт зүйл, ёс заншил, байгаль орчин, түүнтэй хамаарах домог аман яриа гэх мэт зүйлсийг үзмэр хэмээн үздэг ойлголт юм. Энэхүү хөтөлбөр нь өнөө үед мартагдсан, одоогийн оршин суугчид тэр бүр анзаардаггүй тухайн орон нутгийн өвөрмөц өв соёлыг илрүүлэх зорилготой юм. Мөн орон нутгийн амьдрал ахуйтай холбоотой эд зүйлс болон мэдээллийг иргэдээс цуглуулж, эргээд иргэдэдээ сурталчлан таниулдаг юм. Тухайлбал, айлд хадгалагдаж буй хуучин гэрэл зургийг цуглуулах хөтөлбөрийн хүрээнд цуглуулсан гэрэл зурагтай холбоотой мэдээллийг орон нутгийн өндөр настай хүмүүсээс ярилцлага авч цуглуулдаг. Ярилцлага судалгааны ихэнх ажлыг орон нутгийн захиргааны соёлын өвийн ажилтан өөрөө эрхлэн явуулдаг. Харин зарим тохиолдолд хүүхдүүдээр судалгаа хийлгэдэг. Хүүхдүүд нутгийн настай хүмүүсээс ярилцлага авах нь олон нийтийн харилцаа холбоог бэхжүүлэх, орон нутгийн соёлыг өвлөн уламжлуулахын хувьд ихээхэн ач холбогдолтой ажил юм.

“Орон нутгийн мару мару музей” хөтөлбөрийн хүрээнд цуглуулсан мэдээллийг нь орон нутгийн захиргааны соёлын өвийн мэргэжилтэн судалж Орон нутгийн уламжлалын музейд жил бүр үзэсгэлэн зохион байгуулахаас гадна “мару музей архив” хэмээн цахим хэлбэрээр үзүүлж нийтийн хүртээл болгодог. “Мару музей архив” нь орон нутгийн соёлын биет болон биет бус өвийн мэдээлэл, түүнтэй холбогдох иргэдийн ярилцлагын бичлэгийг хадгалдаг мэдээллийн сан бөгөөд өгөгдлийг Digital Earth дээр харуулах болно (Зураг 2).



Зураг 2. Минами-Альпс хотын “Мару музей архив” (<https://archives.maruhakualps.jp/>)

“Орон нутгийн мару мару музей” хөтөлбөр нь Эко музейн зарчимтай адил төстэй арга барил хэмээн үзэж болно. Эко музей нь 1960-аад онд Франц улсад үүссэн бөгөөд 1980-аад оны сүүлээр Япон улсад нэвтрүүлж ил музейн нэгэн төрөл болгосон юм. Эко музей нь “Core (гол цөм)” хэмээн музейн мөн чанар, “satellite (туслах чанарын)” хэмээн орон нутгийн өвөрмөц шинж чанарыг илтгэн харуулах байгаль орчин, соёл, аж үйлдвэрийн биет болон биет бус өв, туслах мөн чанар болон гол мөн чанарыг хооронд нь уялдуулан холбох “trail (зам)”-аар бүрдүүлдэг

юм. Орон нутгийн соёлын өвийг хамгаалахын зэрэгцээ орон нутгийг хөгжүүлэх боломжтой арга барил хэмээн 1990-ээд оноос хойш Япон улс нь орон нутгийн засаг захиргааны хүрээнд сайн ашигладаг болсон.

2.3. Гихү аймгийн Хида хот

Хида Мияагава археологи, угсаатны зүйн музей нь Гихү аймгийн Хида хотод оршино. Тус музей нь хотын төвөөс 30 гаруй км зайтай уулархаг газарт оршдог. Алслагдмал, цас их унадаг, хөдөө байрладаг учраас үзэгчдэд хүртээмж муу, музейн байнгын ажилтан байхгүй байна. Тиймээс одоо хотын захиргааны Соёлын дурсгалын хэлтсийн ажилтан тус музейг хариуцан ажиллуулдаг бөгөөд музей нь жилд ердөө 30 хоног л нээлттэй ажилладаг.

Хүн амын хөгшрөлт³ 40%-аас дээш болж хүн амын тоо цөөрч буй тус нутагт байрлах байнгын ажилтан байхгүй, цөөхөн үзэгчтэй зэргээс шалтгаалан энэ музей нь үйл ажиллагаагаа зогсоох аюулд өртөөд байна. Иймд тус музей нь орон нутгийн иргэдээс гадна өөр хотуудын иргэдийн тусламжтай музейн үйл ажиллагааг үргэлжлүүлж, орон нутгийн соёлын өвийг хамгаалахын төлөө хүчин чармайлт гарган ажиллаж байна. Ийнхүү өөр өөр газарт амьдардаг боловч тухайн орон нутаг болон иргэдтэй тодорхой харилцаа холбоотой хүмүүсийг Япон улсад “Хамааралтай хүн ам (related population)” гэж нэрлэдэг⁴ бөгөөд хүн амын өсөлтийн тоо буурч, хүн ам нь хөгширч буй Япон улсын хөдөө орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжтой хүмүүс хэмээн анхаарал хандуулдаг юм.

Хида хотод соёлын өвийг хамгаалахад “Хамааралтай хүн ам”-ын тоог нэмэгдүүлэх зорилгоор байгуулагдсан сайн дурын байгууллага “Сэкибо клуб” гэж байдаг. Энэхүү клубийн гишүүд нь Хида хотын захиргааны Соёлын өвийн хэлтсийн ажилтан болон тус хотын иргэд тэднээс гадна өөр хотуудад амьдардаг хүмүүсээс бүрддэг байна.

2019 онд байгуулагдсан тус клубийн хамгийн эхний ажил бол “Хамааралтай хүн ам”-тай хамтарч музейн сан хөмрөгт хадгалж буй үзмэрийн гэрэл зургийг авч, цахим хэлбэрээр нийтийн хүртээл болгох хөтөлбөр байжээ. Олон нийтийн цахим сүлжээ ашиглан зар тарааж оролцогчдоо цуглуулжээ. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд “Сэкибо клуб”-ийн үйл ажиллагаа болон Хида хотын соёлын өвийг сонирхсон хүний тоо нэмэгдсэн байна. Тиймээс одоо тус клуб “Хамааралтай хүн ам”-ын сонирхлын түвшинд тохирох хөтөлбөрийг үе шаттай боловсруулан хэрэгжүүлж байна.

Тухайлбал, анхан шат буюу Хида хотын соёлын өвийг хамгаалах үйлсийг сонирхож буй хүмүүст зориулж тус клубийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтийн сүлжээгээр түгээн дэлгэрүүлж, виртуал музей үзүүлдэг. Дараагийн шат буюу сонирхол нь татагдсан иргэд Хида хотод очдог болсон бөгөөд тэдгээр хүмүүст зориулж хөтөч тайлбарлагчтай аялах, лекцэд суух зэрэг

³ Нийт хүн амд эзэлж буй 65-аас дээш настай хүмүүсийн хувь

⁴ Япон улсын Дотоод хэрэг, харилцаа холбооны яам нь “Хамаарах хүн ам”-ыг доорх мэт тайлбарлаж байна: Нүүж ирсэн байнгын оршин суугч ч биш, аяллаар ирсэн зорчигч ч биш, тухайн нутагтай олон янзын харилцаа холбоотой хүмүүс (<https://www.soumu.go.jp/kankeijinkou/>). Энэхүү үзэл баримтлал нь 2016-2017 онд Япон улсад тархсан шинэ ойлголт юм (Sakuno 2019).

боломжуудыг олгодог. Тэдний сонирхол улам бүр татагдаж Хида хотын соёлын өвийн “фен” болсон хүмүүст музейн үзмэрийг 3D-ээр баримтжуулах, түүнийг интернэт сүлжээгээр түгээн дэлгэрүүлэх, нэг өдрийн музейн захирал болох зэрэг музейн менежменттэй холбоотой ажилд оролцох боломж олгодог юм.

“Нэг өдрийн музейн захирал” нь хэд хэдэн удаагийн лекцэд сууж, шалгалт өгч тэнцсэн оролцогчдыг нэг өдрийн музейн захирлаар томилон ажиллуулах хөтөлбөр болно. Тэд урьдчилан тохирсон өдөр музейд ирж сайн дураараа ажилладаг. Энэ бол музей нээлттэй ажиллах өдрийг нэмэгдүүлэх, үзмэр үзэсгэлэнг бодитоор үзүүлэх боломжийг нэмэгдүүлснээрээ ач холбогдолтой хөтөлбөр юм.

2.4. Иватэ аймгийн Ичинохэ хот

Иватэ аймгийн Ичинохэ хотод орших Гошоно археологийн дурсгалт газар нь Жомоны үе буюу 5000 жилийн өмнөх суурин газар юм. Одоо тус газрыг сэргээж Гошоно Жомон парк болгож хамгаалалтад авсан. Мөн парк дотор Гошоно Жомон музей ажилладаг.

Гошоно түүхэн дурсгалт газар нь 1980 онд орон сууцын барилга барихын тулд хийлгэсэн авран хамгаалах судалгаагаар илэрсэн бөгөөд орон нутгийн иргэдийн хүсэлтийн дагуу орон сууцын бүтээн байгуулалтын ажлыг зогсоож тус дурсгалт газрыг хамгаалалтад авахаар шийдвэрлэсэн байна. Энэхүү дурсгалт газрыг 1993 онд улсын хамгаалалтад авчээ. Мөн 2021 онд “Зүүн хойд Япон дахь Жомоны үеийн дурсгалт газрууд”-ын нэг хэсэг болгон Дэлхийн өвд бүртгүүлжээ.



Зураг 3. Гошоно археологийн дурсгалт газрын паркийн ерөнхий байдал

Гошоногийн онцлог нь эртний гэр, байшин барилгуудаас гадна түүний хүрээлэн буй орчин, байгалийг ч гэсэн нөхөн сэргээсэн үйл хэрэг юм. Археологийн малтлага судалгаагаар илэрсэн барилгын материал, хоол хүнс, аж ахуйн тоног хэрэгсэлд ашигласан мод, ургамлын төрөл зүйлийг тодруулан гаргаж парк дотор нөхөн тарьсан байна. Мөн туршилтын археологи (experimental archaeology) болон угсаатны археологи (ethnoarchaeology)-ийн судалгааны хүрээнд иргэдтэй хамтарч

судалгаа явуулдаг⁵.

Гошоно Жомон музейн дэргэд орон нутгийн иргэдийн байгуулсан хэд хэдэн төрийн бус байгууллагатай бөгөөд иргэд тус дурсгалт газрын хөтөч тайлбарлагчаар ажиллах, цэвэрлэх, музейн ажилд туслах зэрэг үйл ажиллагаа явуулдаг. Төрийн бус байгууллагын гишүүд нь тус археологийн дурсгалт газрыг илрүүлснээс хойш түүнийг хамгаалах хөдөлгөөнд оролцож явсан хүмүүс ажээ.

Археологийн дурсгалт газар бол орчин үеийн нийгэмтэй уялдаа холбоо сул байдаг учраас түүний үнэ цэнийг тодруулан гаргаж ойлгуулахад хүндрэл учрах тохиолдол бий. Тиймээс археологийн дурсгалт газрыг хамгаалахад иргэдийн идэвх санаачилга бага байх хандлагатай. Харин Гошоно археологийн дурсгалт газрын хувьд соёлын өвийн хамгаалалтын эхний шат болох судалгаа, хамгаалалтын төлөвлөгөөг боловсруулах үеэс л нутгийн иргэд оролцож хамтран ажилласаар ирсэн нь дараагийн шатны хадгалах, ашиглах үйлсэд иргэдийн оролцоо идэвхжихэд нөлөөлсөн юм.

Хэлэлцүүлэг

Зөвхөн дөрвөн хотын жишээ хэдий боловч дээр дурдсан туршлагаас орон нутгийн иргэдийн идэвх оролцоотой, соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэхэд тус болох санал санаачилгыг авч хэрэгжүүлж болно.

1. Олон төрлийн оролцооны хөтөлбөр ба арга зүй, систем

Төвлөрлийг сааруулах үйл явц өрнөж буй Япон улсад соёлын өвийг хамгаалахад орон нутгийн өвөрмөц шинж чанарт анхаарал хандуулах шаардлагатай болсон бөгөөд (Yamakawa 2018) орон нутгийн хөгжил, соёлын өвийн хамгаалалтын үйл ажиллагааг нягт уялдуулан хослуулан хэрэгжүүлдэг юм. Ийм нөхцөлд орон нутгийн захиргаа болон орон нутгийн музейнүүд нь тухайн орон нутгийнхаа онцлог шинжийг харгалзан үзэж иргэдтэй хамтарч соёлын өвийг хамгаалахаар олон төрлийн хөтөлбөр, арга зүй болон системийг боловсруулж хэрэгжүүлдэг.

Шираока хот нь “орон нутгийн өв соёлын систем”-ийг ашиглаж орон нутгийн хувьд үнэ цэнтэй хэмээн ойлгодог нутгийн өвөрмөц соёлын өвийг олж тогтоон, хууль эрх зүйн дагуу хамгаалалтын төлөвлөгөө боловсруулах хэлбэрээр иргэдтэй тогтвортой хамтран ажиллаж байна. **Минами-Альпс** хотод өнөөг хүртэл иргэд анзаарахгүй ирсэн орон нутгийн өвөрмөц соёлын өвийг хотын захиргааны мэргэжлийн ажилтнуудын судалгаа, үнэлгээгээр илрүүлэн гаргаж Эко музейн аргаар ашигладаг. **Хида** хот бол хүн амын тооны бууралт, насжилтын асуудал тулгарч буй нутаг юм. Харин өөр хотуудад амьдардаг “Хамааралтай хүн ам”-тай хамтарч орон нутгийн түүх, соёлыг хамгаалах зорилготой олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлж байна. **Ичинохэ** хотын гол соёлын өв бол археологийн дурсгалт газар боловч байгаль орчинтойгоо хамт нөхөн сэргээсний үр дүнд парк ба ургамлын менежмент, боловсролын хөтөлбөр зэргээр иргэдийг олноор нь хамруулах

⁵ “Туршилтын археологи (experimental archaeology)” нь туурь, олдворын хувьд түүнийг үйлдсэн, ашигласан хаягдсан эртний хүмүүсийн үйл хэргийг туршилтаар сэргээх судалгаа, “угсаатны археологи (ethnoarchaeology)” нь угсаатны зүйн судалгааны үр дүнгийн дунд ижил төстэй жишээг эрэн сурвалжилж, түүнтэй харьцуулах замаар хэлэлцэх арга зүй ((eds.) Tanaka, Sahara 2003, 360, 848).

боломжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Япон улсын Нарагийн соёлын өвийн үндэсний судалгааны хүрээлэн нь дээр өгүүлсэн орон нутгийн оролцоотой соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааны мэдээллийг цуглуулж судалдаг. Мөн тус хүрээлэн орон нутгийн соёлын өвийн ажилтнуудад зориулсан хурал, семинар болон туршлага солилцох уулзалт зэрэг ажлуудыг зохион байгуулж иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалдаг орон нутгийн захиргаа, тэдний хүчин зүтгэлийг дэмжин ажилладаг.

2. Төр засгийн дэмжлэг

Дээр өгүүлсэн төвлөрлийг сааруулах үйл явц хүчтэй өрнөж буй Япон улсад иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах тохиолдол бараг байхгүй, харин орон нутгийн засаг захиргаа, орон нутгийн төрийн бус байгууллагуудын санаачилсан төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олгох замаар шууд бусаар дэмжлэг үзүүлдэг юм.

Энэхүү судалгаандаа хамрагдсан дөрвөн хотын жишээнээс үзэхэд, СДЗХТХ-ийн дагуу “Орон нутгийн төлөвлөгөө”-г боловсруулсан **Шираока** хот, улсын хамгаалалтад орсон археологийн дурсгалт газрыг иргэдтэй хамтарч хамгаалдаг **Ичинохэ** хот зэрэг нь төрөөс санхүүжилт авах давуу эрхтэй байна. Үүнээс гадна СХА нь орон нутгийн захиргаанаас ирүүлсэн соёлын өвийг хамгаалахад чиглэсэн төслүүдэд санхүүгийн дэмжлэг олгодог юм. **Хида** болон **Минами-Альпе** хотууд нь СХА-аас тэтгэлэг авч иргэдийн оролцоотой үйл ажиллагаагаа явуулсан байна⁶.

3. Оролцогчдын сайн дурын нийгэмлэг байгуулах

Соёлын өвийг иргэдийн оролцоотой, тогтвортой хамгаалах зорилгоор оролцогчид төрийн бус байгууллага байгуулдаг жишээ бий. **Ичинохэ** хотод археологийн дурсгалт газрыг хамгаалах хөдөлгөөнд оролцсон иргэд өөрсдөө музейн дэргэдэх төрийн бус байгууллага байгуулж, өнөөг хүртэл музейтэй хамтран ажиллаж соёлын өвийг хамгаалах үйл ажиллагаа явуулсаар байна. **Хида** хотод захиргааны ажилтны санаачилгаар сайн дурын клуб байгуулж “Хамааралтай хүн ам”-тай идэвхтэй хамтран ажилладаг. Мөн **Шираока** хотын захиргааны ажилтны санаачилгаар “Шираока өв соёлыг хадгалж ашиглах иргэдийн төлөөлөгчдийн хурал” хэмээх байгууллага байгуулж ажилласан. Тус байгууллага нь таван жилийн дотор захиргаанаас салж бие даасан төрийн бус байгууллага болох төлөвлөгөөтэй бөгөөд цаашдаа Шираока өв соёлын системийг иргэд өөрсдөө үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. **Минами-Альпе** хотод соёлын өвийг хамгаалах зорилготой төрийн бус байгууллагууд байхгүй бөгөөд харин орон нутгийн соёлын өвийн ажилтнууд удирдан явуулдаг иргэдийн оролцоотой олон төрлийн хөтөлбөр хэрэгжүүлж иргэдтэй идэвхтэй хамтран ажилладаг.

Дүгнэж хэлэхэд, орон нутгийн оролцоотой соёлын өвийг хамгаалахад оролцогчдод зориулж төрийн бус байгууллага байгуулах нь нэг их шаардлагатай биш, харин оролцогч иргэд өөрсдөө байгуулсан бол орон нутгийн захиргаатай

⁶ Хида хот нь “Орон нутагтай түншлэн хамтарч ажилладаг музейн инновацын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд сан хөмрөгт хадгалж буй соёлын дурсгалуудыг цахимжуулжээ (Miyoshi 2022). Мөн Минами-Альпе хотод “орон нутгийн онцлогтой газар хэвлийн соёлын дурсгалыг ашиглах хөтөлбөр” мэт хөтөлбөрийн хүрээнд боловсрол, сурталчилгааны үйл ажиллагааг явуулжээ (Hosaka 2016).

хамтрахад амар, мөн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон ч үйл ажиллагаа нь тасралтгүй явагддаг байна. Улмаар СХА болон хувийн компани, сангуудаас санхүүгийн тэтгэлэг авахад хувь хүнээс илүү төрийн бус байгууллага нь хамрагдах боломжтой байдгаараа илүү давуу талтай.

Дүгнэлт

Монгол Улсад дээрх нөхцөл байдлыг хангаж ажиллахын тулд судалгаа шинжилгээ, орон нутгийн засаг захиргаа, төр засгийн хувьд дараах үүргийг гүйцэтгэх хэрэгтэй хэмээн үзэж байна.

Судалгаа шинжилгээний хувьд: Монгол Улсад соёлын өвийг хамгаалахад иргэдийн оролцоо чухал шаардлагатай гэдэг ойлголт хараахан нэвтрээгүй байна. Тиймээс судлаачид иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалах ажлын ач холбогдлыг тодруулан гаргаж олон нийтэд таниулах шаардлагатай юм. Түүнчлэн гадаад улс орны сайн туршлагаас судалж, мэдээлэл цуглуулах Монгол Улсад нутагшуулж, практик судалгаа явуулах шаардлагатай байна.

Орон нутгийн засаг захиргааны хувьд: Орон нутгийн иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалах үйл ажиллагааг ерөнхийдөө орон нутгийн соёлын өвийн ажилтан хариуцдаг. Энэхүү ажилтнууд нь тухайн орон нутгийн түүх, соёл, амьдралын хэв маягийн хувьд өргөн цар хүрээний мэдлэгтэй байх ёстой. Түүнчлэн орон нутгийн иргэдийг хүндэтгэж, засаг захиргаа болон иргэдийн хоорондын харилцаа холбоог сайжруулж, түншлэн хамтарч ажиллах чадвартай байх нь зүйтэй.

Төр засгийн хувьд: Орон нутгийн засаг захиргааны явуулж буй иргэдийн оролцоотой үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хуулиар баталгаажуулж, эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгтэй юм. Мөн иргэдийн оролцоотой соёлын өвийн хамгаалалтын судалгааны үр дүн болон бодит туршлагын талаарх мэдээллийг хуваалцах боломж олгох нь бас төрийн чухал чиг үүрэг болно.

Орон нутгийн иргэдийн оролцоотой соёлын өвийг хамгаалах нь зөвхөн тухайн орон нутгийн асуудал биш, бүс нутаг болон төр захиргаа, эрдэм шинжилгээний байгууллагуудын хоорондын уялдаа холбоо, нягт хамтын ажиллагаа чухал шаардлагатай юм.

Санхүүжилтийн эх үүсвэр: Энэхүү судалгааны ажлыг Япон улсын Сүмитомо сангийн судалгааны тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилтээр гүйцэтгэсэн болно.

Ашигласан материалын жагсаалт

Монгол хэлээр:

Нацуки Шимизү, Энхмэнд, С., Ханджав, А. 2017. “Соёлын өвийг хамгаалах ашиглахад нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлж, орон нутгийг хөгжүүлэх системийн судалгаа.” *Орхоны хөндийн өв* 4: 93-103.

Гадаад хэлээр (Япон хэл):

Agency for Cultural Affairs. 2021. 地域総がかりでつくる文化財保存活用地域計画-歴史文化で魅力ある地域へ-. https://www.bunka.go.jp/tokei_hakusho_shuppan/shuppanbutsu/bunkazai_pamphlet/pdf/92911401_01.pdf.

Baba Kenichi. 2022. “A Study on Attempts and Problems like the Ecomuseum in the

- Cultural Heritage Protection Policy: Analysis from the Perspective of Enjoying Culture in the Well-being Community.” *The bulletin of the Faculty of Social Policy and Administration: Reviewing research and practice for human and social well-being* 22: 91-108. <https://doi.org/10.15002/00025442>.
- Hosaka Taichi. 2021. “ふるさと〇〇博物館～掘り起こし・育み・伝えるしかけ～” *観光と考古学* 2: 40-44.
- Komatsu Yayoi. 2001. 文化遺産の保存と活用 仕組と実際. Tokyo: Kubapro.
- Miyoshi Seicho. 2022. “Developing Local Heritage Information with Help from Outside: A Case Study of Hida.” *Recording and Utilization of Cultural Property Information via Digital Technologies* 4: 29-40. <http://hdl.handle.net/11177/9984>.
- Okuno Mugio. 2023. “文化財保存活用地域計画の行方” *Historical Journal* 879: 26-37.
- Sakuno Hirokazu. 2019. “The Significance and Possibility of Relationship Population in Population Decline Society in Japan.” *Annals of the Japan Association of Economic Geographers* 65(1): 10-28. https://www.jstage.jst.go.jp/article/jaeg/65/1/65_10/_pdf.
- Shimizu Natsuki. 2016. “A Study of Community Participation in Cultural Heritage Management in Kharakhorin sum, Mongolia.” *Journal of the Japanese Society for Cultural Heritage* 13: 142-147.
- Shiraoka city, Board of Education of Shiraoka city. 2021. 白岡市文化財保存活用地域計画～地域の文化財を地域の手で守るために～. <https://www.city.shiraoka.lg.jp/material/files/group/31/87913746.pdf>.
- Takada Kazuaki. 2010. “Promotion of Jomon SATOYAMA at GOSHONO Archaeological Site.” *Journal of the Japanese Society for Cultural Heritage* 7: 160-165.
- Tanaka Migaku, Sahara Makoto (eds.). 2003. 日本考古学事典 (2nd ed.). Tokyo. Sanseido.
- Yamakawa Yukinori. 2018. “The Role of Preservation Systems for Local Heritage in the Preservation of Cultural Heritage.” Ph.D. diss., University of Tsukuba.